



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/50

Мандалговь

"Butterfly" подкаст хийлгэх тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8, 20.5.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус аймгийн залуучуудын мэдээ мэдээллээр хангах, чөлөөт цагийг боловсон өнгөрүүлэх зорилгоор 2021 оны 01 дүгээр сарын 14-өөс 04 дүгээр сарын 01-ний хоорондох хугацаанд "Бутадын толгой" ХХК-аар гүйцэтгүүлсүгэй.
2. "Butterfly" подкастыг хийж, хэрэгжүүлэх ажлын хэсгийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Үйл ажиллагаанд шаардагдах 360,000 (Гурван зуун жаран мянган) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг Нягтлан бодогч /С.Чинбат/-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтийг ханган, үр дүнтэй зохион байгуулж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахыг Залуучуудын хөгжлийн төвийн Сургалт хариуцсан ажилтан, ажлын хэсгийн ахлагч (Т.Насандэлгэр), гишүүдэд үүрэг болгосугай.
5. Үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Залуучуудын хөгжлийн төвийн Сургалт хариуцсан ажилтан, ажлын хэсгийн ахлагч /Т.Насандэлгэр/-д даалгасугай.

ДАРГА



Ц. ГАНЗОРИГ

431199997

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2021 оны 25 дүгээр сарын 24 ний өдрийн
150 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



"Butterfly" ПОДКАСТЫН ТӨСВИЙН ТООЦОО

№	Цахим хичээлийн нэрс	Нэг бүрийн үнэ	Давтамж	Нийт
1	Butterfly подкаст	30,000	12 бичлэг	360,000
ДҮН				360,000

----oOo----